

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ГАРЫН АВЛАГА

4

ГАМШГИЙН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ БА МУЗЕЙ

DISASTER RISK MANAGEMENT FOR MUSEUMS



Энэ номыг дахин хэвлэх тохиолдолд зөвшөөрөлтэйгээр орчуулж, эх сурвалжийг дурдаж, хувийг дор заасан ЮНЕСКО (Парис)хаягаар явуулна. Номонд дараах ишлэлийг оруулах:
ЮНЕСКО,2008. Соёлын өвийг хамгаалах ажлын гарын авлага №4. Гамшгийн эрсдлийн менежент ба музей, ЮНЕСКО, Парис.
“Музейн онцгой байдлын хөтөлбөр”-ийн зорилгыг дэмжиж энэхүү номыг хэвлэв.



Хянасан: **Лиз Макдональд**
Бичсан: **Барбара О.Роберт, Жейн К.Хучинс**
Зурсан : **Александар Дони-Сопов**

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс
Чингэлтэй дүүрэг
Самбуугийн гудамж
Засгийн газрын 11-р байр
11 давхар

@UNESCO 2009
CIT/CIH/2008/PI/47

Reproduction is authorized, providing that appropriate mention is made of the source, and a copy sent to the UNESCO (Paris), address below. This document should be cited as :
© UNESCO, 2008. Cultural Heritage Protection Handbook N 4. Disaster Risk Management for Museums, UNESCO, Paris.
Publication done in support of the mission of the Museums Emergency Programme.



Editor: **Lise Macdonald**
Text by: **Barbara O. Roberts, Jane K. Hutchins**
Drawings by: **Aleksandar Dzoni-Sopov**

Russian/English version published
by the UNESCO Office in Tashkent in 2009

9, Ergashev str., 700037 Tashkent, Uzbekistan

© UNESCO 2009
CLT/CIH/MCO/2008/PI/47

АГУУЛГА

CONTENTS

ТАНИЛЦУУЛГА	2	INTRODUCTION
ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЭХНИЙ АЛХМУУД	4	FIRST STEPS IN THE RISK MANAGEMENT PROCESS
БАЙРШЛААС ҮҮДЭХ ЭРСДЛҮҮД	8	RISK FROM LOCATION
Геологи	8	Geological
Газар зүй	10	Geographical
Цаг уур	13	Meteorological
Барилга байгууламж	15	Structural
АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	16	MAINTENANCE
БАРИМТЖУУЛАЛТ	19	DOCUMENTATION
ЗААХ ТЭМДЭГ БА БҮДҮҮВЧ ЗУРАГ	22	SIGNS AND MAPS
ХАРИЛЦАА ХОЛБОО	24	COMMUNICATION
Харилцаа холбооны аргууд ба анхаарах асуудлууд	26	Ways of Communicating and Issues to Consider
Олон нийттэй харилцах	27	External Communication
МЭРГЭЖЛИЙН ШИЛДЭГ ТУРШЛАГА	28	PROFESSIONAL BEST PRACTICES
ЮУНЫ ӨМНӨ ХҮМҮҮСИЙГ ХАМГААЛАХ	31	PROFESSIONAL PRIORITIES 31
ОНЦГОЙ БАЙДАЛД БЭЛЭН БАЙХ	32	EMERGENCY PREPAREDNESS
ХАРИЛЦААНЫ СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ	35	ESTABLISHING A RESPONSE NETWORK
СУРГАЛТ	37	TRAINING
Сургалтын аргууд	39	Approaches to Training
ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДСЭН АЛХМУУД	42	BASIC STEPS TOWARD RISK REDUCTION
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ	45	MONITORING

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлагын зорилго нь онцгой байдлын үед соёлын өвд учирч болзошгүй хохирлыг бууруулахын тулд байнгын мэдлэгтэй байх, төлөвлөх, харилцаа холбоо тогтоох ба арга хэмжээ авах талаар музейн ажилтнуудад удирдамж өгөхөд оршино. Эн тэргүүн анхаарах асуудал нь хүмүүсийг хамгаалах бөгөөд хүмүүсийн аюулгүй байдал хангагдмагц соёлын өв, сан хөмрөгийг хамгаалах, хэвийн ажиллагааг үргэлжлүүлэх нь ажилтнуудын мэргэжлийн үүрэг юм.

Эрсдлийн менежмент нь түвэгтэй мэт санагдаж болох бөгөөд ойлголтыг энгийнээр тодорхойлвол; онцгой байдлын үед танд болон танай байгууллагад учирч болзошгүй эрсдлийг бууруулахад тус болох, та бүхэнд байгаа ур чадвар, нөөц болопцоог ашиглан тэдгээрийг шаардлагатай түвшинд хүргэх, зохион байгуулалттай мэдээлэл ба сургалт юм.

Сан хөмрөгийг аажмаар сүйтгэх аюултай хортон шавьж, харьцангуй чийгшилтийн хэлбэлзэл ба хэт чийгтэй орчинд үүсэх хөгцрөлт зэрэг хор хөнөөлтэй тэмцэх, урьдчилан хамгаалах стратегийн талаар бусад эх сурвалжаас танилцахыг Танд зөвлөж байна.

Олон Улсын Музейн Зөвлөл (ОУМЗ- ICOM), Сэргээн Засварлалтын Гетти институт (СЗГИ-GCI), Соёлын өвийг хамгаалах ба сэргээн засварлах сургалтын Олон улсын төв (СӨХХССОУТ- ICCROM) хамтран ЮНЕСКО-гийн Соёлын эд зүйлс ба биет бус соёлын өвийн газрын Музей ба соёлын өвийн хэлтсийн дэмжлэгтэйгээр ОУМЗ-ийн “Музейн онцгой байдлын хөтөлбөр” (МОБХ-МЕР)-ийн хүрээнд “Онцгой байдлын үед цогц менежментийг багаар хэрэгжүүлэх” сургалтын хөтөлбөрийг боловсруулав. МОБХ(-МЕР)-ийн хөтөлбөрийн ном зүй: <http://gcibibs.getty.edu/asp/>.

Дээрх сэдвээр ОУМЗ-ийн холбогдох цахим хаяг:
http://icom.museum/risk_management.html



INTRODUCTION

The purpose of this publication is to guide museum staff through the ongoing cycle of awareness, emergency planning, communication and actions that will reduce damage to cultural heritage in an emergency situation. Protecting people is the highest priority. Once life safety issues have been addressed, safeguarding cultural property is part of the professional mission of staff working to protect and preserve collections and reestablish business continuity.

Risk Management can be a daunting concept and to make the subject more approachable, we will define the term as using skills and resources that you have, others you may need to obtain, and information and training you may wish to consider, to minimize the risks you and your institution may face, in a major emergency event. We suggest you refer to other sources for preventive strategies to deal with slow and destructive hazards such as insect damage, relative humidity changes, or mold in a rainy season.

The International Council of Museums (ICOM), The Getty Conservation Institute (GCI) and the International Centre for the Study of the Preservation and Restoration of Cultural Property (ICCROM) have established in partnership a training program entitled Teamwork for Integrated Emergency Management supported by the Section of Museums and Cultural Objects of the Division of Cultural Objects and Intangible Cultural Heritage of UNESCO, in the framework of the ICOM's Museums Emergency Programme (MEP). The helpful MEP Bibliography is available at <http://gcibibs.getty.edu/asp/>.

ICOM also has a website that may be useful:

http://icom.museum/risk_management.html



ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЭХНИЙ АЛХМУУД

Эрсдлийн менежмент нь эргэлдэх дугуй мэт тасралтгүй ажиллагаа юм. Байгууллагын Онцгой байдлын бичмэл төлөвлөгөөг боловсронгуй болгохын тулд давуу талыг бий болгох, болзошгүй ослын үе түүний өмнө ба дараах үед юу хийх ба одоо юу хийгдсэн байгааг нягтлан үзнэ.

Эрсдлийн менежмент бол таны эрсдэл, эмзэг байдалд дүгнэлт шинжилгээхийх, зорилго, стратегийг тодорхойлох, эрсдлээсурьдчилан сэргийлэх ба бууруулах ажиллагааг сайжруулах, хохирлыг арилгах шинэ аргад сургах, үнэлгээ дүгнэлт хийх цогц ажиллагаа юм.

Барилга ба сан хөмрөгт тохиолдож болзошгүй аюулыг тооцоолж, ялангуяасан хөмрөгийн гол эрсдэл, хохирлыг нэг бүрчлэн тодорхойлж, тэдгээрийг бууруулах стратеги, санхүүгийн болон ажилтнуудын нөөцийг үр дүнтэй ашиглах талаар төлөвлөх шаардлагатай. Энэ нь гамшиг болтол тайван байснаа гэнэт гамшиг дайрах үед чадах бүхнээ хийх гэж чармайхаас илүү үр дүнтэй, илүү хямд болно. Жишээ нь: барилга ажлын байраа цэвэр, эмх цэгцтэй байлгах нь гал гарахаас урьдчилан сэргийлж, онцгой байдлын үед хүмүүс ба сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх замуудыг чөлөөлнө.

FIRST STEPS in the Risk Management Process

Think of the process as a wheel that keeps turning; things to think about, setting priorities, actions to take before, during and after your next emergency and reviewing what was done in order to improve a written institutional Emergency Plan.

Risk management is assessing your risks and vulnerabilities, setting sustainable goals and strategies, improving preventive and mitigation measures, learning new methodologies and using response and recovery techniques and back again to assessment. The cycle goes on.

Consider all the threats to your building and collection, identify the main risks to the collection, the damage each might cause, start work on mitigation strategies and use financial and staff resources effectively. This is cheaper and more effective than waiting for a problem to happen and trying to salvage what you can in a disaster setting. For example, cleaning up your building may prevent a fire and clear passageways for people and movement of collections during an emergency.

ЭХНИЙ АЛХМУУД

FIRST STEPS



Эрсдлийн менежментийн урт хугацааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд ажилтнуудын болон бусад нөөцийн тусламжтайгаар ямар давуу тал байгаа, хир хугацаа зарцуулах талаар бодитой хандаж тодорхойлно. Ажилтнууд ба үзэгчдийн тоонд үндэслэн эрсдлийн менежментийн төлөвлөгөө боловсруулна. Өдөр, шөnө, хоногийн ажиллагаа ба хариуцах ажлуудыг ялган тусгана.

Be realistic about priorities and how long it may take to achieve sustainable risk management goals with staff and resources available. Base risk management planning on the numbers of staff and visitors. Consider the 24 hour cycle, day and night actions and responsibilities may be different.



-Танай байгууллага ба орон нутаг, улс, олон улсын хэмжээнд юу болж байгаа тухай мэдэж байх.


It is good to stay current with what is happening in your institution and with local, national and international affairs.



Бэлэн байх. Мэдээлэл хайж олох. Мэдлэг чадвар, харилцаагаа өргөжүүлж, онцгой байдлыг тодорхойлох, хөнгөвчлөх ба ажиллах чадвараа дээшлүүлэх шаардлагатай.

Be prepared. Seek out information. Increase your skills, awareness, connections, and abilities to identify, mitigate, and respond to an emergency.

БАЙРШЛААС ҮҮДЭХ ЭРСДЭЛ /ГЕОЛОГИЙН/ RISKS FROM LOCATION /GEOLOGICAL



Танай байгууллага байгалийн гамшигт өртөж болох эсэхийг тодорхойлох:

- Газар хөдлөлт
- Галт уулын идэвхжил
- Цунами
- Чулуу нурах
- Орон нутгийн онцлог байгалийн гамшгууд


Find out whether you are subject to major natural hazards such as:

- Earthquakes
- Volcanic action
- Tsunami
- Rock falls
- Specific local hazards



Хөрсний гулсалтыг судлах. Хөрсний дээжийн судалгаа нь барилгын доод давхаргын талаар мэдээлэл болж чадна.

Research the kind of ground motion to expect, soil samples provide information on the layers under your structures.



Галт уулын идэвхжилтэй бүсэд байгаа бол галт уулын байдлыг ажиглах.

In a volcanic region, research how the volcano is expected to behave.



Тухайн бүс нутаг цунамийн эрсдэлтэй бол барилгын дотор ба гаднах аюулгүй газарт очих замыг судлаж мэдсэн байх. Хүмүүс ба сан хөмрөгийг гол уснаас холдуулж хир зэрэг хол зөөж аюулгүй газар аваачихыг товлосон байх.

If tsunamis are anticipated, know routes to safety inside and outside of your building and how far inland people or collections may have to go to be safe.



Танай орон нутаг ба байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц голын усны түвшин нэмэгдэх ба цаг агаар өөрчлөгдөх тухай мэдээг шуурхай олж авах.

Seek information on how rising seawater levels and climate change may affect your municipal and institutional operations.




Танай байгууллага зам харилцааны дэд бүтцэд ойр байршилтайгаас гарч болох аюул ослоос хэрхэн хамгаалах арга замыг тодорхойлох.

Consider how to protect your institution against problems that may arise because of proximity to transportation infrastructure.




Танай барилгын байршил ба орчин тойрон нь осол үүсгэхэд нөлөөлөх эсвэл шалтгаан нь болох эсэхэд дүгнэлт хийлгэх.

Assess if the placement of your building or site could influence or cause an emergency.




Хот, орон нутгийн орчин тойрон нь яаралтай тусламжийн хурд, цар хүрэй ба авран хамгаалах менежментийн техник аргад нөлөөлнө. Тухайн орон нутгийн нөхцөл байдалд зохицуулан ажиллах хэрэгтэй. Танай музей гаднаас тусламж авч чадахааргүй тусгаарлагдсан биш биз?

Urban or rural settings will affect the rate and range of assistance and response management techniques. Adapt to your circumstances. Could your site be cut off from help?



Газар дорхи археологийн дурсгалуудыг хамгаалахад дээр нь баригдсан барилгын аюулгүй байдалд янз бүрийн бэрхшээлийг бий болгодог.

Protecting archeological sites below ground level will present different challenges to protecting buildings above.




Байгууллагын орчин тойронд зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл ба түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар мэдэх нь зүйтэй.

It is a good idea to know your transportation routes and how to use them effectively.



Танай орон нутаг ба бүсэд болж байсан цаг агаарын таагүй үзэгдлүүд, хэрэв тийм үзэгдэл дахин тохиолдвол ажилтнууд, үзэгчид, хөдлөх, ул хөдлөх, биет ба биет бус соёлын өвийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх талаар судлах.

Research the history of severe meteorological events in your region and locality and how they may affect the safety of staff, visitors, immovable, movable or intangible cultural property if such an event occurs again.



Цаг агаарын гэнэтийн өөрчлөлт үзэгдлийн эрсдлийг одоо байгаа эмзэг байдалтай харьцуулан судлах, хор хөнөөлийг бууруулж чадах арга хэмжээнүүдийн дэс дарааллыг тогтоох.

Analyze your risks versus your vulnerability to such events and establish priorities for mitigation measures.



Танай нутаг дэвсгэрт ихэвчлэн ямар салхитай байдгийг мэдэх. Галт уулын үнс нурам, элсэн шуурга, химийн бодисын утааны чиглэлд салхи нөлөөлнө.

Find out about prevailing winds in your area. These will effect the direction and fall of volcanic ash, blowing sand, fumes from a chemical spill accident, etc.




Байгалийн болзошгүй гамшгууд : үер, ган, халалтаас үүсэх гал түймэр, хүчтэй салхи, хар салхи, тронадо, тайфун, элсэн ба цасан шуурга, хүчтэй бороо, мөндөр болон орон нутгийн онцгой үзэгдлүүд.

Consider: floods; drought; brush fires; high winds; hurricanes; tornadoes/typhoons; sand storms; snow storms; ice storms; other local conditions.



Барилга байгууламж нь байгалийн болон хүнээс үүдэлтэй янз бүрийн аюул заналд хир өртөмтгий болох талаар судалж үнэлэх, эрсдлийн түвшингээр эрэмблэх.

Assess and prioritize how your structure(s) will respond to different hazards, natural or man-made.



Барилгын дотор ба гаднаас сан хөмрөгт тохиолдож болох аюул ослыг тооцоолж судлах. Жишээлбэл; хэрэв үзмэрийн хоргыг хананд эсвэл шаланд бэхлэгүй бол газар хөдлөлтөд хөдлөх буюу унаж болох юм. Доод давхар усанд автах эрсдэлтэй бол сан хөмрөгийн дээд давхаруудад нүүлгэх эсвэл гадагш гаргах.

Assess and prioritize how your collections will respond to the hazards that may affect them inside or outside of your building. For example, show cases may move or fall in an earthquake unless you fix them to a wall or to the floor. If the ground floor may flood, you may need to move collections up or out.

АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

DOCUMENTATION



Зарим оронд барилга байгууламжийн тухай хууль дүрэмд зөвхөн барилгад тавигдах энгийн стандартыг заасан байдаг. Боломжтой бол музейн барилгыг шинэчлэн сайжруулах зардлыг төсөвт тусгах.

Building codes in some countries may provide a minimum lawful standard; budget for upgrades if possible.




Барилгын дээвэр, усан хангамжийн ба ус зайлзуулах хоолой, цахилгааны, халаалтын шугамуудыг зохих ёсоор ажиллаж байгаа эсэхийг шалгах, үйлчилгээ хийх. Шаардагдах засвар шинэчлэлийг байнга хийж байх.

Inspect and maintain your roofs, gutters, drains, electrical wiring, and plumbing. Try to do the necessary repairs/replacements.



Аж ахуй, цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах ба тэдний ажлын байрны тодорхойлолтод холбогдох ажлын эрсдлийн (усны хоолой бөглөрөөгүй эсвэл ус алдаж байгаа газар байгаа гэх мэт) байдлын тайлангийн тухай тусгах.

Review training for housekeeping and cleaning staff and incorporate risk assessment reporting (such as unblocking a drain or reporting a water leak) into normal duties.



Яаралтай хэрэглэгдэх багаж хэрэгслийг байвал зохих байранд нь байрлуулах ба ажилтнуудыг хэрэглэж сургах. Хэрэглэх багаж хэрэгслээ барилга дотор орж авч чадахгүй тохиолдолд хэрхэн ажиллах талаар тооцох.

Store tools and quick response supplies on site and train staff to use them. Consider what to do if you cannot go into the building to get the equipment you need.



Ажилтнуудыг усны, хийн, цахилгааны самбарууд мөн ус шүрших хоолой, гал унтраагчийг ажиллуулж сургах.

It is recommended to train staffs how to operate water, gas and electrical shut-off valves, pumps, and fire extinguishers.

БАРИМТЖУУЛАЛТ

DOCUMENTATION



Бичигдсэн тэмдэглэл баримтууд ба гэрэл зургууд нь мэргэжилтнүүдэд маш чухал зүйл юм. Соёлын өвийн цуглуулга нь өргөн хүрээг хамардаг боловч бүх үйл явдал бүрийн тухай өгүүлж чадахгүй.

Written records and photo documentation are essential to professional staff. Cultural heritage collections can be extensive and it is impossible to remember every fact, detail or item.




Баримт бичгийн эх болон хуулбарын хувийг өөр газар хадгалах хэрэгтэй. Бичгүүд хадгалагдсан барилга осолд өртөж дотогш орох боломжгүй тохиолдол гарч болох юм.

Records and duplicate records off-site are advisable, and necessary, for example, if you cannot gain access to a damaged building where your records are stored.



Дараах баримт бичгүүдийг байнга шинэчлэн баяжуулж байх: барилгын ба бусчиллийн бүдүүвч зураг, ажилтнуудын нэрсийн жагсаалт, холбоо барих хумүүсийн, дэд бүтцийн байгууллагуудын ба онцгой байдлын албаны ажилтнуудын болон түрээслүүлсэн үзмэрүүдийн тухай мэдээлэл, соёлын өвийн бүртгэлүүд, гэрэл зургийн ба даатгалын мэдээлэл.

It is good to update regularly: building and systems maps; staff lists and contact information; vendor information; emergency response agency information and contacts; inventory of cultural holdings; loan information; photo documentation; insurance information.



Эрсдлийн менежментийн бодлого ба түүнийг хэрэгжүүлэх зааврыг боловсруулна. Тухайлбал; гамшигийн үед ажилтнууд ба сан хөмрөгийг аврах хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах төлөвлөгөөнүүдийг тус бүр боловсруулах.


It is recommended to prepare risk management policies and procedures, for example: Staff Emergency/Evacuation Plan; response Plan for Collections; Fire Safety Plan; Public Relations Plan.




Олон улсын ба үндэсний мэргэжлийн байгууллагуудаас мэргэжлийн стандарт ба шилдэг туршлагын талаар мэдээллийг байнга авах (ЮНЕСКО, Олон Улсын Музейн Зөвлөл-ICOM, Хөшөө Дурсгалт газруудын Олон улсын Зөвлөл- ICOMOS, Соёлын өвийг хамгаалах ба сэргээн засварлах сургалтын Олон улсын төв – ICCROM, Соёлын өвийг хамгаалах ба сэргээн засварлах сургалтын Олон улсын төв -ICCROM, Сэргээн засварлах Гетти институт - GCI).

It is a good idea to keep informed of professional standards and best practices through international and national professional bodies (UNESCO, ICOM, ICOMOS, ICCROM, GCI etc.)


ЗААХ ТЭМДЭГ БА БҮДҮҮВЧ ЗУРАГ SIGNS AND MAPS



Заах тэмдгүүд үнэн зөв, одоогийн байршлыг заасан, тод харгаж байгаа эсэхийг шалгах




Check that signs are accurate, current and clearly visible.



Барилгын төлөвлөгөө ба бусчиллийн будүүвч зургийн хуулбарыг байгууллага ба өөр газарт хадгалах. Эдгэр нь засварын ажлын үед хэрэгтэй.

Store copies of architectural plans and systems plans on site and offsite. They will be needed during recovery procedures.



Музейн барилгын ба нутаг дэвсгэрийн бүдүүвч зураг нь ажилтнууд ба үзэгчид аюулгүй газар очих замыг олоход тусална.

Local maps are helpful to assist staff and visitors to find other ways to safety.

ХАРИЛЦАА ХОЛБОО

COMMUNICATION



Эрсдлийн менежментийн бодлого ба түүнийг хэрэгжүүлэх зааврууд нь аюулгүй байдлыг хангах бөгөөд харилцаа холбооны асуудал нь бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Risk management policies and procedures promote safety and communication is an essential component.




Эрсдлийг бууруулахад харилцаа холбооны олон төрлийн арга хэрэгслийг ашиглана. Харилцаа холбооны мэргэжилтнүүд нь ажилтнууд хоорондоо болон олон нийттэй харилцаа тогтоох талаар сургалт зохиоход туслана.

Managing risk uses many types of communication actions and devices. Professional communication specialists can help train staff to communicate effectively with each other and with members of the public.




Байгууллагын дотоод холбоог ашиглалтад бэлэн, чөлөөтэй байлгах нь онцгой байдлын үед ажилтнууд мэдээлэл түгээх, шийдвэр гаргахад тустай.

Clear lines of institutional communication will help keep staff informed during an emergency and ensure good decision-making.



Барилгын дотор ба орчин тойрны хөдөлгөөний чиглэлүүдийг олон нийтэд ойлгомжтой үзүүлсэн заах тэмдгүүд онцгой байдлын үед болон энгийн өдрүүдэд ч үзэгчид, ажилтнууд ба сан хөмрөгт эрсдлийг бууруулах тустай.

Providing clear direction to members of the public about how to move in and around a structure during normal and emergency operations will help minimize risk to visitors, staff, and the collection.



1. Танилцуулга

- Ихэвчлэн харилцаа холбооны олон аргыг ашиглах хэрэгтэй. Тухайлбал; гараар бичсэн эсвэл хэвлэсэн зарлан мэдээлэл, утсаар ярих, интернетээр мэдээ дамжуулах ба мэдээллийн цахим сэтгүүл гаргах гэх мэт.

2. Дуу авиаагаар холбоо тогтоох

- Дуут дохио (сонсголын бэрхшээлтэй хүн дуут дохио сонсохгүй байж болно)
- Ярьж зааварчилгаа өгөх (тантай харилцаж буй хүн таны ярьж байгаа хэлээр ярьдаггүй байж болно)

3. Дурс тэмдгээр холбоо тогтоох

- Онцгой байдлын удирдамж (гарах тэмдэг, онцгой байдлын гэрэлтүүлэг, бүдүүвч зураг, давхруудын гэрэлтүүлэг, өнгөөр ялгасан хэсэг/шугамууд).
- Бичмэл заавар, удирдамж, ойлгомжтой бичсэн санамж ба баримт бичгүүд.

4. Харилцааны физик аргууд

- Төрөл бүрийн хаалтууд
- Чиглүүлэх (гараар дохио өгөх, гар чийдэн зэрэг багаж хэрэгслийг ашиглан хүмүүсийг авран хамгаалахад туслах)
- Хүмүүсийг тайвшуулах, сандралыг намжаах (ажилтнууд эсвэл сайн дурын туслагчид хүмүүсийг зөв чиглэл рүү тайван итгэлтэйгээр дагуулна)

1. Introduction:

- Multiple forms of communication are needed under most circumstances and these may, on occasion, include hand written or typed notes, electronic media such as telephone, email, text message, and web bulletins.

2. Audible communication

- Alarms (a person with a hearing disability may not know that an alarm has sounded).
- Spoken directions (the person you are speaking to may not speak your language).

3. Visual communication

- Emergency guidance (exit signs, emergency lighting, maps, floor lighting, painted paths/lines).
- Written procedures and guidelines, good records and documentation.

4. Physical communication

- Barriers of differing types
- Guidance (assisting people to safety using hand signals and tools, such as flashlights).
- Reassurance (staff or volunteers who calmly and authoritatively to encourage others to follow appropriate directions).



Эрсдлийн менежмент нь олон нийтийн хэвлэл мэдээллийн талаар өргөн мэдлэгтэй байх, сэтгүүлчид хэрхэн ажилладаг, ямар мэдээлэл сонирхдог талаар мэдэхийг шаардана.

Good risk management includes an understanding of the media, how journalists work, and what information they may seek.



Сайтар зохион байгуулсан харилцаа холбоо нь хямралын үед олон нийтэд зөв ойлголт төрүүлэх бөгөөд ажилтнуудад хэрэгцээтэй мэдээллийг хүргэх хэрэгсэл болж чадна: - байгууллагыг төлөөлөх ажилтныг томилох, сургах, албан ёсны төлөөлөгч нь үнэн, бүрэн гүйцэд мэдээлэл авах боломжийг хангах, олон нийтэд соёлын өвийг хайлран хамгаалах, туслах талаар зөв мэдээлэл удирдамж өгч туслалцааг өргөн хүрээтэй болгоно.

Effective communication can shape public understanding during an emergency and also be a tool for reaching staff with important messages: designate and train a spokesperson to represent the institution; ensure that the spokesperson receives accurate and complete information; communities value cultural property and may provide assistance in time of crisis if they receive good information on how to help effectively.

МЭРГЭЖЛИЙН ШИЛДЭГ ТУРШЛАГА

PROFESSIONAL BEST PRACTICES



Хүмүүсийг хамгаалах нь эхний зорилго юм. Ажлын жирийн өдруудэд ч музейн ажилтнууд өөрсдийгөө болон барилга тоног төхөөрөмж, сан хөмрөгийг хэрхэн хамгаалах талаар байнга бодож тооцоолж байх.

Safety for people comes first. The key for museum staff is to do their daily work with safety always in mind, for themselves, for the structure(s) and for the collections.



Цагдаа, гал түймэртэй тэмцэх, түргэн тусламжийн албатай хэрхэн холбогдохыг мэддэг байх. Гал түймэр гарах, ус алдах ба сэжигтэй этгээдийн талаар ямар мэдээлэл шаардлагатай байдгийг мэддэг байх.

Know how to contact fire, police, and ambulance; understand what information is required to report a fire, water leak or suspicious person.



Өдөр тутам болон онцгой байдлын үеийн удирдлагын сайн бүтэц зохион байгуулалттай байх. Онцгой байдлын үед Та юу хийх ёстойгоо мэддэг байх.

It is good to understand the institutional chain of command for normal and emergency operations. Know what is expected of you in an emergency.



Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй танилцсан байх; хэрэв төлөвлөгөөгүй бол төлөвлөгөө боловсруулах ажлыг шуурхай эхлүүлэх.

Familiarity with the institution's emergency plan is recommended if one exists; advocate for such a plan if the institution does not have one.



Юу мэдэхгүй байгаагаа мэдэх, санаа зоволтгүй асуух, мэдээллээ дахин лавлах.

Be aware of what you do not know and do not be shy about asking questions or double-checking your information.



Танай байгууллагын үйл ажиллагааны явцад ямар бэрхшээлтэй асуудал гарч болохыг шалгах, үзэгчидтэй холбоотой болон бусад гэнэтийн зүйл гарвал ажилтан хэрхэн шийдвэрлэж чадахыг хэлэлцэн байх.

It is good to check on problems that may represent a liability for the institution and be clear about what museum staff may do when faced with difficult visitors or other challenging circumstances.

ЮУНЫ ӨМНӨХҮМҮҮСИЙГ ХАМГААЛАХ

PERSONAL PRIORITIES



Хүмүүсийг хамгаалах нь хамгийн эхний зорилго.

Safety for people comes first.



Энгийн үед онцгой байдал гарахаас урьдчилан ажилтнуудын ажилтнуудын ажилтнууд хамт ажилладаг хүмүүсийнхээ гэр булийнхнийг сайн мэддэг, тэдэнд онцгой байдлын талаар танилцуулсан, юу хийх тухай ойлгуулсан байвал зохино.

It is good to set up a family communication network before an emergency happens. Staff work better if they know their families are prepared and know what to do.

ОНЦГОЙ БАЙДАЛД БЭЛЭН БАЙХ

EMERGENCY PREPAREDNESS




Онцгой байдлын үед ажиллах зохион байгуулалтын бүтэц бий болгох, ажилтнуудын хариуцах ажлын хуваарь ба авах арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхой тусгасан төлөвлөгөө боловсруулах.

It is recommended that an organized structure be established and job responsibilities and descriptions of actions to be taken in the event of an emergency are written down in a clear plan.



Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан зөв зохион байгуулалттай удирдлагын бүтэц нь онцгой байдлын ажиллагааг хөнгөвчилж чадна: захирлын томилсон ажилтан онцгой байдлын үеийн ажиллагааг зохицуулж удирдана; захиргаа, ажилтнууд, хамгаалалт, аж ахуй ба сан хөмрөгийг хариуцсан гол ажилтнууд онцгой байдлын зохицуулагчид мэдээлэл өгөх, таваас долоон хүнтэй шуурхай баг ажиллах бөгөөд гишүүд тус бүр мэдээлэл хүргэнэ.

A streamlined command structure, illustrated in the Emergency Plan, can simplify emergency efforts: one person in charge of coordinating and leading response efforts, designated by the director; key personnel, representing the administration, staff, security, facilities and collections, report to emergency coordinator; five to seven people, reporting to an individual form an effective team.



Онцгой байдлын үед шаардагдах багаж хэрэгсэл, материалыг нэг дор цуглуулж бэлтгэх. Шуурхай ажиллах ур чадвар нь шийдвэрлэх нөлөөтэй.

Assemble tools and supplies to help respond to emergency events. The ability to react quickly may be critically important.



Хоргодох төлөвлөгөө. Янзүүрийн нөхцөл байдалд аюулгүй газар хаана байх, үзэгчид хаана цуглах, танай баг хаана цуглахыг мэдсэн байх. Жишээлбэл: хар шуурга, хуй салхи, цунами-н үед хаана хоргодох? Гал түймрийн үед барилгаас хүмүүсийг хэрхэн гаргах? Гал гарах үед байрнаас гарах, хар салхи болох үед найдвартай газар олж хоргодох. Цаг хугацаа байгаа бол сан хөмрөгийг хаана хэрхэн зөөж хадгалах.

Plan refuges. Know where to seek safety in different situations, where visitors should gather, and where to meet your team members. For example: Where to shelter in a tornado, hurricane or tsunami? How to evacuate a building during a fire? In a fire leave the building; in a tornado sheltering in place may be appropriate. How and where to shelter the collection if time permits?



Ажилтнуудыг сургаж бэлтгэх шаардлагатай. Ажилтнуудыг байнга сургаж дадлагажуулах нь онцгой байдлын үед бүх ажилтнууд өөрсдийн үүрэг хариуцлагаа сайтар мэдэж, тайван, уян хатан, үр дүнтэй ажиллахад тустай.

It is recommended to prepare the staff. Regular drills will ensure that all staff are familiar with their responsibilities and respond in a calm, flexible and effective manner when and if an emergency arises.



Нэхцэл байдлын үнэлгээний үе шатанд хэрэгцээ ба эн тэргүүний зорилтыг тооцоолон сан хөмрөг, үзүүллэг дэх үзмэрүүдийг онцгой байдалд бэлтгэнэ.

It is recommended to prepare the collections, on display and in storage, based on the needs and priorities established during the assessment phase.

АЖИЛЛАГААНЫ СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ ESTABLISHING A RESPONSE NETWORK



Удирдах байгууллагууд ба холбогдох албадтай нягт холбоотой ажиллаж, тэдгээрийн танайд үзүүлж чадах үйлчилгээний хүчин чадал, нөөцийг сайн мэдсэн байх.

It is a good idea to work with public authorities and response agencies and be aware of the capabilities and resources that may be available to you.



Ижил төстэй хамтран ажилладаг байгууллагуудтай харилцан туслалцах гэрээ байгуулах.

It is good to establish mutual aid agreements with sister institutions.

АЖИЛЛАГААНЫ СУЛЖЭЭ БАЙГУУЛАХ ESTABLISHING A RESPONSE NETWORK



Үйлдвэрлэгчидтэй нягт харилцаа тогтоож, нийлүүлэгчидтэй худалдааны гэрээ байгуулах.

It is recommended to work with vendors and set up purchasing agreements with suppliers.



Сургалт бол онцгой байдалд бэлэн байх ажиллагааны зайлшгүй чухал хэсэг бөгөөд байгууллагын багаар ажиллах чадварыг сайжруулна.

Training is an essential part of emergency preparedness and also helps to promote teamwork in an institution.



Гэнэтийн ослын үед үзэгчид нь музейн ажилтнууд юу хийх, хүмүүсийг аюулгүй газар яаж хүргэхийг мэдэж байгаа гэж итгэдэг. Бэлтгэл сургалт нь ажилтнуудад айж сандарсан хүмүүстэй хэрхэн ажиллах дадлыг эзэмшүүлдэг тул чухал ач холбогдолтой.

Visitors will expect staff to know what to do and how to take them to safety. Training sessions for staff are essential because practice is necessary for working with groups of people who may be concerned or frightened.



Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу хүмүүс ба сан хөмрөгийг барилга ба тухайн газраас хэзээ, ямар арга замаар нүүлгэн шилжүүлэх дадлага хийнэ. Онцгой байдлын үед бүр хэцүү болж болох юм.

Using the written emergency plan, practice how and when to evacuate people or collections materials from a building or site. In an emergency, conditions may become progressively more difficult.



Онцгой байдлын үеийн авран хамгаалах ажиллагааны зааврыг байнга боловсронгуй болгож, шинэчилж байхыг анхаарах.

Try to establish an ongoing process for improving procedures and help to keep them current.



Сургалтыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулах. Дуут дохио өгөх, ажилтнуудыг нүүргэн шилжүүлэх, хурал цуглаан товлож цуглуулах, дараагийн ажиллагааг хэлэлцэх. Авран хамгаалах ажиллагааны цагийн хуваарийг хийх, жишээлбэл, 10 мин, 30 мин, 12 цагийн дотор юу хийх, сургалтын “онцгой байдлын үе”-д ажилтан хэрхэн ажиллах дасгал сургууль хийлгэх, боломжтой бол орон нутгийн захираганаас төлөөлөгч урьж сургалтад оролцуулах.

Hold drills of different types. Sound alarms, evacuate the staff, gather at meeting points, and consider the next actions. Include a timeline, consider what to do (for example) in 10 minutes, in 1 ½ hours, in 12 hours, or schedule exercises in which staff respond to a mock “event” and invite local agencies to join you for the training if appropriate.



Сургалтын үе шат бүрийг хэлэлцэх, дүн шинжилгээ хийх. Ажилтан бүр сургалтын байдал ба дараагийн шатанд юу хийх талаар санал хүсэлтээ хэлэх. Ажилтнууд бусадтай хуваалцах их мэдлэгтэй байдаг.

Review each training session. All staff should be encouraged to comment and to offer suggestions for doing things better next time. Staff has great knowledge to share.



Дараах сургалтын арга техникийг ашиглан ажилтнуудын авран хамгаалах чадавхийг дээшлүүлэх :

- Онцгой байдлын сэдвээр зохиомжлох (Жишээ нь: хүчтэй шуурга болох тохиолдолд ажилтнууд юу хийх вэ?)
- Дадлагын дасгалууд (нарийн түвэгтэй боловч тулгарч болох бодитой тохиолдлыг багаар хэлэлцэж, авран хамгаалах ажиллагааг харьцуулах)

Improve response capabilities by using teaching techniques such as:

- Scenarios (For example, high winds are expected... What should staff do?).
- Table top exercises (More elaborate but realistic problem, discuss actions in groups or teams and compare responses).



Онцгой байдлын үед сан хөмрөгийг хэрхэн аврах талаар багийн бэлтгэл сургууль хийлгэх. “Гэмтсэн”, норж муудсан үзмэрүүдийг дууриалган хийсэн хуулбаруудыг ашиглан дасгал хийх. Сэргээн босгох ажилд шаардагдах цаг хугацаа ба талбайн хэмжээ нь хүмүүст өөр мэдрэмж төрүүлнэ.

Train teams for handling collections in emergency situations. Try an exercise using “damaged” or wet materials that simulate artifacts. The amount of time and space that is needed for “recovery” work will be a surprise to everyone.



Эрсдлийн менежментийн ажиллагаанд хэн ямар үүрэгтэй оролцох дадлага хийх. Хүмүүсийг ба музейд хадгалахад буй соёлын өвийг хамгаалах чадавхи, хэрэгжүүлэх ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах, гэнэтийн онцгой байдал бий болоход аюулгүй байдлыг хангахад ямагт бэлэн байх.

Practice roles and responsibilities in the risk management process, act to improve capabilities and safety measures for people and the cultural heritage in your care and be ready to do a great safe job in the next emergency situation.

ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДСЭН АЛХМУУД

BASIC STEPS TOWARD RISK REDUCTION



Онцгой байдлын тайван бус үед хайж явахын оронд барилгыг дотно гаднагүй бүрэн явж үзэх, орох гарах хаалгууд, бүх замыг урьдчилан мэдэх.

Walk through building and know all ways of going out of or into the structure before you have to do so in an emergency situation.



Онцгой байдал үүсэхэд барилгын орох ба гарах гарцууд, эргэн тойрны хөдөлгөөнийг хорьж, анхааруулах тэмдэг байрлуулах.

Secure the perimeter, exits and entrances to the building in an emergency.



Барилгаас гарах зам, хаалгыг саадгүй чөлөөтэй байлгах нь аюулгүй байдлыг хангах бөгөөд галын хор хөнөөлийг багасгана. Ажилтнуудын урьдчилан сэргийлэх ба эрсдлийг бууруулах ажиллагааг дэмжих, туслах.

It is a good idea to help improve security and reduce fire risk by keeping exit routes clear. Encourage and support preventive and mitigation actions by all staff.



Эрсдлийн талаар мэдээлэх үүргийг ажилтан эсвэл албадад хүлээлгэсэн байх, жишээ нь: хортон шавьж, усны хоолой хагарах, хаалга таглах, хий алдах, цахилгааны утасны ба унтраалганы гэмтэл, сан хөмрөгийн орчинд санаатайгаар нэвтрэх гэх мэт. Эрсдлийн талаар өөрийн ажил үүргийн шугамаар болон шуурхай багийн гишүүний хувьд мэдээлж байх.

Take responsibility for reporting and addressing risks, for example: Insects; dripping pipes; blocked doors; gas smell; faulty lights or switches; vermin in collection areas. It is good to report risks both as part of normal duties and as part of a response team.



Онцгой байдлын ажлын төлөвлөгөөг байнга хэлэлцэж байх ба эрсдлийн менежментийн ажиллагааг тусгаж шинэчлэх.

Update and revise the emergency plan to reflect accomplishments of risk management activities.

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ MONITORING



Дараах ажилбаруудыг тасралтгүй хэрэгжүүлэх; -үзлэг, дүн шинжилгээ, ажилтнуудын сургалт, барилгын хамгаалалт, ашиглалт үйлчилгээ, зааврууд ба сан хөмрөгийг баримтжуулах, хэрэгжүүлэх зааврууд ба Онцгой байдлын төлөвлөгөө болно.

Establish cycle of review, analysis, and revision for staff training, building security, maintenance, documentation of procedures, collections, response procedures and Emergency Plan(s).




Цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, байгаль болон хүнээс шалтгаалах аюул осол гарах тохиолдолд байнга бэлэн байх.

Be alert to changing weather conditions, natural and man-made hazards.




Ажилтнуудын ур чадварыг сайжруулах, сургалтын хуваарийг боловсруулах, байгууллагын чадавхийг дээшлүүлэхэд анхаарах, боломжтой бол орон нутгийн нөөц боломжийг ашиглах.

Keep in touch with the improving skills of staff, schedule training, and increase capabilities and institutional capacity to respond to a situation, if possible, with local resources.



Орон нутгийн дэд бүтцийн өөрчлөлтүүдийн талаар тухай бүр шуурхай мэдээлэлтэй байх.

It is advisable to stay informed of local infrastructure changes.



шомжийн
сэвүүлэсэн



изээгдсэн
хөтөлбөр



чадсан
хөтөлбөр

Мэргэжлийн тусалцаа авах, үйлчилгээ болон материал ханган нийлүүлэх харилцах сүлжээний талаар мэдээллийг байнга шинэчлэх.

It is recommended to update networks of resources, both for professional assistance and services and supplies.

**Аюулгүй байдлын талаар байнга санаж
сээрэмжилж, амьдарья ажиллада.**

**Эрсдлийн сайн менежмент нь бүх ажилтнуудаас
байнгын хүч чармайлт шаардана.
Онцгой байдал тохиолдвол гамшиг болох ёсгүй.**

**Live and work with safety in mind.
Good risk management requires
a sustained effort by all staff.**

Your next emergency need not become a disaster.

DDC
069.53'068
C-526

Орчуулсан : **Д. Цэдмаа**
Хянан тохиолдуулсан : **Д. Бумаа**
Ариутган шүүсэн: **Л. Мөнхзүл, Ү.Сарантуяа**
МОНЦАМЭ агентлагийн хэвлэлийн газарт 500 хувь хэвлэв.
Улаанбаатар, 2011 он

ISBN 978-99962-918-3-8



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

